

БАТЛАВ.**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН****Д.БУМ – ОЧИР****АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ****Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага****1.1.Хууль зүйн шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж, мөн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно” гэж, мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заасан.

Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн гэрээ болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын¹ 2 дугаар зүйлд “... энэхүү пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй. ...” гэж, энэ пактын 25 дугаар зүйлд “Иргэн бүр 2 дугаар зүйлд дурдсан аливаа алагчлалгүйгээр болон үндэслэлгүй хязгаарлалтгүйгээр дараах эрх, боломжийг эдэлнэ: ... жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох ...” гэж тус тус заасан.

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1257>

Эдгээр зохицуулалтыг цогцоор нь авч үзвэл иргэн бүр сонгуульд оролцох (сонгох, сонгогдох) тэгш боломжоор хангагдсан байхаар Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ зэргээр тодорхойлсон байна. Энэ утгаараа Улсын Их Хурлын байна уу, эсвэл орон нутгийн Хурлын байна уу гэдгээс үл хамааран сонгуульд оролцох тэгш боломж нь сонгуулийн өрсөлдөөний нөхцөл, оролцогч бүрд шударгаар үйлчлэх, улмаар сонгох, сонгогдох эрхийг эдлүүлэх урьдач нөхцөл болно. Учир нь сонгуульд оролцох аль нэг талд бусдаас давуу байдлыг зохих үндэслэлгүйгээр олгох нь сонгуульд шударгаар өрсөлдөх нөхцөлийг алдагдуулна. Тиймээс сонгуульд оролцох тэгш боломжийг бүрдүүлэх, холбогдох хууль зүйн баталгааг хангах үүргийг төр хүлээж байна. Орон нутгийн Хурлын төлөөлөгчид ажлын ажлын тайлангаа тараах, уулзалт хийх давуу байдлыг олгосон хэр нь бусад иргэнд хориглосон агуулгыг илэрхийлж байгаа нь сонгуульд оролцох тэгш боломжийг хязгаарласан шинжтэй байна.

Иймд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсэгт “Орон нутгийн Хурлын төлөөлөгч сонгуульд нэр дэвших бол энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тойргийн сонгогчдодоо ажлын тайлангаа танилцуулах зорилгоор хийсэн уулзалт, энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ болон тараасан тайлан нь сонгуулийн сурталчилгаанд хамаарахгүй” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ зэргээр тодорхойлсон иргэний эдлэх эрх, боломжийг ялгаварлан гадуурхалгүйгээр эдлүүлэх хүний эрх, эрх чөлөөний үзэл баримтлал, үндсэн агуулга, суурь зарчимд нийцэхгүй байна.

1.2. Практик шаардлага

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хууль тогтоомжийг **нийт 5 удаа** шинэчлэн баталсан байх бөгөөд эдгээрийн сүүлийн 2 хууль тогтоомж буюу 2015, 2020 оны хуулиудад Улсын Их Хурлын гишүүн, орон нутгийн Хурлын төлөөлөгч нэр дэвшиж байгаа тохиолдолд тэдгээрийн хийсэн ажлын тайлан, уг тайлангаа танилцуулах зорилгоор тойргийн сонгогчидтой хийсэн уулзалт, хуулиар хориглоогүй арга хэмжээ зэрэг нь сонгуулийн сурталчилгаанд тооцогдохгүй, хамаарахгүй байхаар тус тус зохицуулан хэрэгжүүлж ирсэн нь хууль тогтоомжийн харьцуулалтаас харагдаж байна. Энэ хугацаанд өмнө дурдсанчлан Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрх, эрх чөлөөний суурь зарчим зөрчигдөж, холбогдох хууль зүйн баталгаагаар бүрэн гүйцэд хангагдаагүй ирсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсэгт ажлын тайлангаа тараах, сонгогчидтой уулзалт хийхийг зөвшөөрсөн нь орон

нутгийн Хурлын төлөөлөгч сонгогчидтой нягт холбоо, эргэх хариуцлагатай байх гэсэн хууль ёсны зорилготой гэж үзэхээр байна. Энэ хүрээнд орон нутгийн Хурлын төлөөлөгчийн сонгогчидтойгоо уулзалт, хэлэлцүүлэг хийхийг хууль ёсны гэж хүлээн зөвшөөрч, сонгогчдыг төрийн үйл хэрэгт татан оролцуулах явдлыг дэмжих замаар энэ шаардлагыг хангана гэж үзэх боломжтой. Гэвч Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсэгт орон нутгийн Хурлын төлөөлөгч өөрсдийн хийсэн ажлын тайлангаа тараах, энэ тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой уулзалт хийх гэсэн зөвхөн нэг талын ажиллагааг тусгасан байна.

Орон нутгийн Хурлын төлөөлөгч иргэдээс сонгогдож төлөөлж байгаа тул бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлсэн талаараа тайлагнах нь зүйтэй хэмээн хууль тогтоогч үзэж ажлын тайлан тарааж болохоор зохицуулсан байна. Тодруулбал, анхлан ийм агуулгатай заалтыг анх хуульчлах үед буюу 2015 оны Сонгуулийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.13 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгч, орон нутгийн хурлын төлөөлөгч нэр дэвшиж байгаа тохиолдолд тэдгээрийн хийсэн ажлын тайлан сонгуулийн сурталчилгааны материалын хэмжээнд тооцогдохгүй” гэж заасныг жишээ болгон дурдаж болох юм. Өөрөөр хэлбэл, орон нутгийн Хурлын төлөөлөгч үйл ажиллагаагаа тайлагнах нь зүй ёсны боловч үүний тулд сонгуульд оролцох тэгш боломжийг алдагдуулж, тодорхой этгээдэд давуу байдал олгож болохгүй юм. Тухайлбал,

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20–ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн² 41 дүгээр зүйл (Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материал хэвлүүлэх, тараах, хүргэх)–ийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй” гэж, мөн хуулийн 44 дүгээр зүйл (Сонгогчтой хийх уулзалт, хурал, цуглаан)–ийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй” гэж тус тус заасныг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 2 дугаар сарын 26–ны өдрийн 03 дугаар дүгнэлтээр “... Улсын Их Хурлын гишүүн нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө хийсэн ажлынхаа тайлан тараах, уг тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой уулзалт хийхийг илт зөвшөөрч, харин Улсын Их Хурлын гишүүн бус иргэнд ийнхүү зөвшөөрөөгүй байна. Эдгээр зохицуулалт нь тодорхой, тохирсон, ялгаварлан гадуурхаагүй байх зарчмыг хангахгүй байх тул иргэний сонгуульд оролцох тэгш боломжийг алдагдуулсан ...” гэсэн үндэслэлээр Монгол Улсын Үндсэн

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14869>

хуулийн холбогдох (1.2, 14.1, 14.2, 16.9) зүйл, заалтыг зөрчсөн тул түдгэлзүүлсэн.³ Уг дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны 3 дугаар сарын 27–ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” 32 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрч,⁴ 2025 оны 4 дүгээр сарын 18–ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсгийг хүчингүй болгож, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгийг “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө аливаа этгээд хийсэн ажлын тайлангаа танилцуулахаар зохион байгуулсан уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй” гэж өөрчлөн найруулсан.⁵ Үүний үр дүнд, нэр дэвшигч хэн гэдгээс үл хамааран Улсын Их Хурлын сонгуульд оролцох тэгш боломж хууль зүйн хувьд баталгаажсан боловч, орон нутгийн Хурлын сонгуульд оролцох тэгш боломж хангагдаагүй нээлттэй үлдсэн байна. Үүнээс улбаалан Улсын Их Хурлын сонгууль болон орон нутгийн Хурлын сонгуульд ялгамжтай зохицуулалт, зарчим үйлчлэх эрх зүйн орчинг бий болгож байна.

Энэ утгаараа, орон нутгийн Хурлын төлөөлөгч бус иргэн нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө өөрийн хийсэн ажлын тайлангаа тараах нь сонгогчдын санал татах зорилгоор эд зүйл тараасанд эсхүл зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийсэнд тооцогдохоор байх боловч орон нутгийн Хурлын төлөөлөгч ийнхүү тайлан тараахыг уг хуулийн 47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсгээр зөвшөөрсөн байна. Нөгөөтээгүүр, орон нутгийн Хурлын төлөөлөгч нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой уулзалт хийхийг илт зөвшөөрсөн боловч ийм уулзалт хийхийг орон нутгийн Хурлын төлөөлөгч бус иргэнд зөвшөөрсөн эсэх нь тодорхойгүй байна.

Дээрх зохицуулалтаар хийсэн ажлын тайлангаа танилцуулах, уулзалт хийхийг орон нутгийн Хурлын төлөөлөгчид илт зөвшөөрч, бусад иргэнд ийнхүү зөвшөөрөөгүй нь зайлшгүй бус, тэнцвэргүй байх тул орон нутгийн Хурлын төлөөлөгчид бусад иргэнээс илүү давуу байдлыг зохих үндэслэлгүйгээр олгож, ялгаварлан гадуурхсан шинжтэй байна. Сонгуулийн жилд сонгуульд оролцохтой холбогдуулан иргэдэд зохих үндэслэлгүйгээр ялгаатай хандаж болохгүй. Орон нутгийн Хурлын төлөөлөгч болохынхоо хувьд бусад этгээдээс эрх зүйн байдлын хувьд ялгаатай субъект мөн боловч сонгуулийн жил эхэлснээр нэр дэвшихээр бол нэр дэвших сонирхол бүхий бусад иргэнтэй адил субъект тул хуулийн хязгаарлалт, эрх, үүрэг нэгэн адил үйлчлэх учиртай. Тиймээс сонгуулийн жилд сонгуулийн сурталчилгааны хугацаанаас өмнө буюу нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэх хүртэл орон нутгийн Хурлын төлөөлөгч

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17430499735542>

⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17430782762882>

⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17431229037072&showType=1>

хийсэн ажлын тайлангаа танилцуулах, уулзалт хийхийг зөвшөөрч байгаа бол үүнтэй адил үйл ажиллагааг орон нутгийн Хурлын төлөөлөгч бус иргэнд мөн адил зөвшөөрч, нэр дэвшихээр төлөвлөж байгаа бүх иргэнд сонгуульд оролцох тэгш боломж олгох ёстой.

Уг зохицуулалт нь сонгуулийн тойрогт нэр дэвших сонирхол бүхий орон нутгийн Хурлын төлөөлөгч болон бусад иргэний хооронд ажлаа тайлагнах замаар өөрийгөө таниулах тэгш бус боломжийг улам нэмэгдүүлэхээр байна. Үүний зэрэгцээ орон нутгийн Хурлын төлөөлөгчид хуулиар хориглоогүй бусад арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвшөөрөх замаар давуу байдал олгосон байна.

Иймд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсгийг өөрчлөн найруулах нь зүйтэй гэж үзэв.

Хоёр. Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү хуулийн төсөл нь 2 зүйлтэй бөгөөд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсгийг өөрчлөн найруулахаар тусгасан.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байх, хүнийг эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж болохгүй гэсэн хүний эрх, эрх чөлөөний Үндсэн хуулийн зарчим хангагдах ач холбогдолтойн зэрэгцээ Монгол Улс хүний эрхийн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэд биелүүлж байгааг илтгэн харуулна.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хуулийн төслийг дагаж бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

